



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 03/01

Арвайхээр сум


Г Төлөвлөгөө батлах тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйл 20.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг нэгдүгээр, хяналтын ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөө хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган, хэрэгжилт үр дүнг хагас, бүтэн жилээр тооцон ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (С.Ундрах)-д даалгасугай.

ДАРГА



Т.НАРАНГАРАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 28 дугаар сарын 17-ны өдрийн
09/01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНААР 2025 ОНД
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэлэлцэх асуудлууд	Хэрэгжүүлэх хугацаа	Асуудал танилцуулах хэлтэс, агентлаг, албан тушаалтан	Холбогдох Хороо
1.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар 2025 онд хэлэлцэх асуудлын болон хяналтын төлөвлөгөө батлах тухай	I улирал	ИТХ-ын нарийн бичгийн дарга	Ажлын алба
2.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хороодын ажиллах журам батлах тухай	I улирал	ИТХ-ын нарийн бичгийн дарга	Ажлын алба
3.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн ёс зүйн дүрэм батлах тухай	I улирал	ИТХ-ын нарийн бичгийн дарга	Ажлын алба
4.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ёс зүйн хорооны ажиллах журам батлах тухай	I улирал	ИТХ-ын нарийн бичгийн дарга	Ажлын алба
5.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, түүний хэрэгжилтийг тооцох журам батлах тухай	I улирал	ИТХ-ын нарийн бичгийн дарга	Ажлын алба
6.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны үйл ажиллагааны журам батлах тухай	I улирал	ИТХ-ын нарийн бичгийн дарга	Ажлын алба
7.	Аймгийн сонгуулийн хороог татан буулгах тухай	I улирал	Аймгийн ЗДТГ-ын дарга	Нутгийн удирдлага, эрх зүйн бодлогын хороо
8.	Нөхөн сонгуулийн тов тогтоох тухай	I улирал	ИТХ-ын нарийн бичгийн дарга	Ажлын алба
9.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай	I улирал	Нийгмийн бодлогын хэлтэс	Нийгмийн бодлогын хороо
10.	"Багш хөгжил" хөтөлбөр батлах тухай	I улирал	Нийгмийн бодлогын хэлтэс	Нийгмийн бодлогын хороо
11.	Тарат сумын Туяа багийн бага сургуулийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	I улирал	Боловсролын газар	Нийгмийн бодлогын хороо

12.	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн жагсаалт батлах тухай	I улирал	Аймгийн ЗДТГ-ын дарга	Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хороо
13.	Аймгийн ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай	I улирал	Аймгийн ГХУСАЗСЗ-ийн нарийн бичгийн дарга	Нутгийн удирдлага, эрх зүйн бодлогын хороо
14.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын норматив шинэчлэн батлах тухай	I улирал	Мал эмнэлгийн газар	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хороо
15.	"Хүүхэд хамгааллын бодлого батлах тухай" аймгийн ИТХ-ын 2015 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнгийн тухай	I улирал	Нийгмийн бодлогын хэлтэс	Нийгмийн бодлогын хороо
16.	Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн тухай (Хүүхэд хамгааллын тухай хуулийн 38.1.3 -т "Жилд хоёроос доошгүй удаа тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, чиглэл өгөх заалтын дагуу)	I улирал	Аймгийн Хүүхдийн зөвлөл	Нийгмийн бодлогын хороо
17.	"Онги ус суваг", "Хархорин ус суваг", "Өв Эко" мийт, "Өв агро" гурил тэжээлийн үйлдвэр ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, өөрчлөлт оруулах тухай	I улирал	Аймгийн Орон нутгийн өмчийн газар	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
18.	"Аймгийн эдийн засгийг 2014-2024 он хүртэл хөгжүүлэх бодлогын баримт бичиг батлах тухай" 2014 оны 9/07 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнгийн тухай	I улирал	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хороо
19.	"Арвайхээр хотын агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийг үнэлэх тухай" аймгийн ИТХ-ын 2023 оны 17/02 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнгийн тухай	I улирал	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо
20.	"Баянтээг түлш" ОНӨХХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, цаашид авах арга хэмжээний тухай	I улирал	"Баянтээг түлш" ОНӨХХК	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
21.	"Гэр бүл хүний хөгжлийн төв" ОНӨУТҮГ-ын үйл ажиллагаа, цаашид анхаарах асуудлын тухай	I улирал	"Гэр бүл хүний хөгжлийн төв" ОНӨУТҮГ	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо

22.	“Үндэсний аюулгүй байдлыг орон нутгийн түвшинд хангах бодлого батлах тухай” аймгийн ИТХ-ын 2021 оны 04/03 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнгийн тухай	I улирал	Цэргийн штаб	Нутгийн удирдлага, эрх зүйн бодлогын хороо
23.	Тогтоол хүчингүй болгох тухай	I улирал	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Нутгийн удирдлага, эрх зүйн бодлогын хороо
24.	“Баянтээг” ОНӨХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн тухай	II улирал	“Баянтээг” ОНӨХК	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
25.	“Хужирт Эрдэс баялаг” ОНӨУТҮГ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, цаашид авах арга хэмжээний тухай	II улирал	“Хужирт эрдэс баялаг” ОНӨТҮК	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
26.	“Онги-Ус суваг” ОНӨХХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, цаашид авах арга хэмжээний тухай	II улирал	“Онги-Ус суваг” ОНӨХХК	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
27.	“Хархорин-Ус суваг” ОНӨХХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, цаашид авах арга хэмжээний тухай	II улирал	“Хархорин ус суваг” ОНӨХХК	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
28.	“Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨХХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, цаашид авах арга хэмжээний тухай	II улирал	“Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨХХК	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
29.	“Өв эко мийт” ОНӨХХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, цаашид авах арга хэмжээний тухай	II улирал	“Өв эко мийт” ОНӨХХК	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
30.	Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай	II улирал	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	Нутгийн удирдлага, эрх зүйн бодлогын хороо
31.	“Халуун ам бүл” төсөл батлах тухай	II улирал	Нийгмийн бодлогын хэлтэс	Нийгмийн бодлогын хороо
32.	“Хайрлагдсан хүүхэд” төсөл батлах тухай	II улирал	Нийгмийн бодлогын хэлтэс	Нийгмийн бодлогын хороо
33.	Хүмүүнлэгийн хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгийн тухай (Аймгийн ИТХ-ын 2019 оны 56 дугаар тогтоол)	II улирал	Нийгмийн бодлогын хэлтэс	Нийгмийн бодлогын хороо

34.	“Үхэр сүрэг” хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн тухай (Аймгийн ИТХ-ын 2023 оны 20/08 дугаар тогтоол)	II улирал	Хөдөө аж ахуйн газар	Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо
35.	“Таван төрлийн малын үржлийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилт, үр дүнгийн тухай (Аймгийн ИТХ-ын 2021 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан)	II улирал	Хөдөө аж ахуйн газар	Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо
36.	“Атаршсан газрын хэмжээг нэмэгдүүлэх тухай” аймгийн ИТХ-ын 2022 оны 13/01 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнгийн тухай	II улирал	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо
37.	Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2024-2032 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг батлах тухай	II улирал	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хороо
38.	2024 оны санхүүгийн тайлангийн гүйцэтгэл, аудитын дүгнэлтийн тухай	II улирал	Санхүү төрийн сангийн хэлтэс	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
39.	Өвөрхангай, аймгийн нийтийн эдэлбэр газрын зориулалт, түүний хэмжээ, зааг, ашиглалтын журам батлах тухай	II улирал	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хороо
40.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй хэрэгжилт удааширч, хугацаандаа ашиглалтад ороогүй барилга угсралтын ажил болон 2025 онд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний тухай	II улирал	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хороо
41.	Дулааны станцын барилга, шугам сүлжээний ажлын явцын тухай	II улирал	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хороо
42.	Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө батлах тухай	II улирал	Аймгийн Засаг даргын орлогч	Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо

43.	“Таримлыг тариалангийн талбайн сэлгээнд тариалах тухай” аймгийн ИТХ-ын 2017 оны 15 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнгийн тухай	II улирал	Хөдөө аж ахуйн газар	Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо
44.	Аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагаа, үр дүнгийн тухай	II улирал	Аймгийн Засаг дарга, Нийгмийн бодлогын хэлтэс	Нийгмийн бодлогын хороо
45.	Нийгмийн халамжийн зорилтот бүлэгт үзүүлж буй хүнсний талон олгох үйлчилгээ, үр дүнгийн тухай	II улирал	Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар	Нийгмийн бодлогын хороо
46.	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах дасан зохицох арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай	III улирал	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо
47.	“Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр”-ийн хэрэгжилт үр дүнгийн тухай (Аймгийн ИТХ-ын 2022 оны 13/03 дугаар тогтоол)	III улирал	Нийгмийн бодлогын хэлтэс	Нийгмийн бодлогын хороо
48.	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн сургалт, нийгмийн баталгааг дэмжих орон нутгийн хөтөлбөр батлах тухай	III улирал	Нийгмийн бодлогын хэлтэс	Нийгмийн бодлогын хороо
49.	Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнгийн тухай	III улирал	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Нийгмийн бодлогын хороо
50.	Өвөрхангай аймгийг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай	III улирал	Ажлын хэсэг	Нийгмийн бодлогын хороо
51.	Өвөрхангай аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай	III улирал	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хороо
52.	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хэрэгжилтийн тухай	IV улирал	Байгаль орчны газар	Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо

53.	Арвайхээр сумын орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын тайлан, цаашид авах арга хэмжээний тухай	IY улирал	“Арвайхээр тохижилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ, “Арвайхээр цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ, “ Арвайхээр гэрэлтүүлэг” ОНӨААТҮГ	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
54.	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилт, үр дүнгийн тухай	IY улирал	Засаг дарга	Нутгийн удирдлага, эрх зүйн бодлогын хороо
55.	Өвөрхангай аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тухай	IY улирал	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хороо
56.	2025 онд ойгоос бэлтгэсэн модны гүйцэтгэл, 2026 онд ойгоос бэлтгэх модны тоо, хэмжээ тогтоох тухай	IY улирал	Байгаль орчны газар	Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо
57.	Аймгийн 2025 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны орон нутгийн төсвийн төслийн тухай	IY улирал	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
58.	Шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг сунгах тухай	I, II улирал	ИТХ-ын нарийн бичгийн дарга Ажлын хэсэг	Нутгийн удирдлага, эрх зүйн бодлогын хороо
59.	Нийтийн сонсголын тов тогтоох тухай	I, III улирал	ИТХ-ын нарийн бичгийн дарга	-
60.	Орон нутгийн байгууллагыг нэрэмжит болгох тухай	Жилдээ	Нийгмийн бодлогын хэлтэс	Нийгмийн бодлогын хороо -
61.	Өмч, хөрөнгө шийдвэрлэх тухай	Жилдээ	Аймгийн орон нутгийн өмчийн газар	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
62.	Хяналт шалгалтын ажлын дүнгийн тухай	Жилдээ	Ажлын хэсэг	Хурлын хороод



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 43 дугаар сарын 17-ны өдрийн
43/дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2025 ОНЫ
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Чиглэл	Үндэслэл	Хугацаа	Хамтран ажиллах талууд
НЭГ. ИЛТГЭЛ МЭДЭЭЛЭЛ СОНСОХ				
1	Аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргаас дэмжлэг үзүүлж буй тухай	Боловсролын ерөнхий хуулийн 30.1.3 дахь заалтад “Насан туршийн суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” гэж заасан.	VI сар	Аймгийн Засаг дарга, Нийгмийн бодлогын хэлтэс-Нийгмийн бодлогын хороо
2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй хэрэгжилт удааширч, хугацаандаа ашиглалтад ороогүй барилга угсралтын ажил болон 2025 онд хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний тухай мэдээллийг сонсох	Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны 2.3.1.5 “Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлэн тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, бүртгэлийг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих, хариуцах” гэж заасан.	VI сар	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс – Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хороо
3	Нийгмийн халамжийн зорилтот бүлэгт үзүүлж буй хүнсний талон олгох үйлчилгээ, үр дүнгийн тухай	Нийгмийн халамжийн тухай хуулийн 23.1 дэх хэсэгт “Нийгмийн халамжийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захирааганы төв байгууллага, орон нутагт тухайн шатны Засаг дарга тус тусын эрх хэмжээний хүрээнд эрхэлнэ” гэж заасан.	VI сар	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар –Нийгмийн бодлогын хороо

4	Дулааны станцын барилга, шугам сүлжээний ажлын явцын талаарх илтгэл мэдээллийг сонсох	МУЗНДНТУТ хуулийн 39.1.5 дахь заалтад "Хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонсголыг хэлэлцэх, санал гаргах" гэж заасан.	III сард	Аймгийн Засаг дарга – Төсөв, эдийн засгийн бодлогын хороо, Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хороо
ХОЁР.ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ				
1	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээсэн эсэхэд хяналт шалгалт хийх	Байгаль хамгаалах тухай хуулийн 16.1.1 дэх заалтад "Нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих" гэж заасан.	IX сар	Хүнс, хөдөө аж ахуйн, байгаль орчны бодлогын хороо
2	Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ хийгдсэн газруудын нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Байгаль хамгаалах тухай хуулийн 16.1.1 дэх заалтад "Нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих" гэж заасан.	IV, VIII сар	Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хороо
3	"Баянтээг түвш" ОНӨХХК-ий үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.2.4 дэх заалтад "Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих" гэж заасан.	I улирал	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
4	"Онги Ус суваг" ОНӨХХК-ий 2024 оны үйл ажиллагаа болон төсвийн гүйцэтгэлд хяналт шалгалт хийх	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.2.4 дэх заалтад "Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих" гэж заасан.	III сар	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
5	Хужирт суманд баригдаж байгаа Төрийн албан хаагчдын орон сууцны барилгын явцад хяналт шалгалт хийх	МУЗНДНТУТ хуулийн 35.1.15 дахь заалтад "Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавих" гэж заасан.	III сар	Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хороо
6	Уянга, Бат-Өлзий, Баянгол суманд баригдсан мал нядалгааны цехийн хөрөнгө оруулалт, гүйцэтгэл, үр дүнд хяналт шалгалт хийх	МУЗНДНТУТ хуулийн 35.1.15 дахь заалтад "Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавих" гэж заасан.	II улирал	Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хороо

				хороо, Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хороо
7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд хэрэгжих зарим хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт шалгалт хийх	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30.2.2 дахь заалтад "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээ, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авах" гэж заасан.	IV сар	Нийгмийн бодлогын хороо
8	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх	Шилэн дансны тухай хуулийн 8.1 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгүйн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ" гэж заасан.	VI, XII сар	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
9	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төрөх, эмэгтэйчүүдийн эмнэлгийн гадна фасадын засварын ажилд хяналт шалгалт хийх	2024 оны 02/12 дугаар 2025 оны төсөв батлах тухай тогтоолын 4-р хавсралт "Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-ын шинээр эхлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний 1 дэх хэсэг	VII сар	Хөрөнгө оруулалт, төлөвлөлт, хөгжлийн бодлогын хороо, Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
ГУРАВ. НИЙТИЙН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ				
1	Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэл, үр дүнд төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах тухай	Нийтийн сонсголын тухай хуулийн 9.3 дахь хэсэгт "Засгийн газар, төрийн захиргааны төв, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага дараах асуудлаар төсвийн хяналтын сонсголыг жил бүр зохион байгуулна" гэж заасан.	IV сар	Төсөв, эдийн засгийн бодлогын хороо
2	Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх болон энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тариф тогтоосон тогтоолын хэрэгжилтэд ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах тухай	Нийтийн сонсголын тухай хуулийн 8.5 дахь хэсэгт "Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор ерөнхий хяналтын сонсголыг тогтмол явуулах бөгөөд тухайн хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт хүчин төгөлдөр болсноос хойш 24-30 сарын дотор эхний хяналтын сонсголыг, дараагийн сонсголыг таван жил	X сард	Нутгийн удирдлага, эрх зүйн бодлогын хороо

		тутамд нэгээс доошгүй удаа заавал зохион байгуулна" гэж заасан. Аймгийн ИТХ-ын 2019 оны "Тариф тогтоох тухай" 11/02 дугаар тогтоол.		
--	--	---	--	--

---oOo---